



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/343

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, 4.1 дэх хэсэг, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2026 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бугат сумын ахмадын хороо аймгийн ахмадын хороотой хамтран баруун бүсийн сумдын "Спортын бага наадам"-ыг 06 дугаар сард зохион байгуулахтай холбогдуулан дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 1,890,000 (нэг сая найман зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар) -т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

